



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАРХАН СУМЫН 11-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
“НОГООН БАЙГУУЛАМЖ”-ИЙН ТӨСӨЛ

Төсөл боловсруулсан: О.Батмаа

2026 он

НЭГ. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дархан-Уул аймгийн 15-р багийн нутаг дэвсгэрт Сургуулийн өмнөх боловсролын 165 хүүхдийн цэцэрлэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулан 2015-09-01-ний өдрөөс эхлэн хүүхэд багачуудаа хүлээн авч СӨБ олгох үйл ажиллагааг явуулж байна.

Тус цэцэрлэг энэ хугацаанд хүүхдэд ээлтэй таатай орчинг эцэг эх, асран хамгаалагчид, багш ажилчидын дэмжлэгтэйгээр бий болгон тохижуулж ажиллаж ирсэн болно.

ТӨВ ЦЭЦЭРЛЭГ болон САЛБАР ЦЭЦЭРЛЭГИЙН гадна талбай нь нийт байх хувь хэмжээ нь одоогийн байдлаар:

- Авто зогсоол 100% тай
- Зам талбайн гэрэлтүүлгийн 56% тай
- Туршилт танин мэдэхүйн сургалтын талбайн 40% тай
- Ногоон байгууламж 52% тай байгаа болно

Манай цэцэрлэгийн хувьд ногоон байгууламж бий болгох боломж нь нийт талбайн 76%-ийг эзэлж байна. /энэ хувь хэмжээ нь эко сургууль цэцэрлэгийн үнэлгээгээр хийгдсэн болно/

Манай цэцэрлэг нь АЛСЫН ХАРАА-2050, “ЭКО СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ ХӨТӨЛБӨР”-ийг 2022 оноос хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах, мөн хүүхдийн хөгжих орчинд тав тух тайтай эрүүл орчинг бий болгоход та бүхнийг хамтран ажиллаж дэмжинэ гэж найдаж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ЗОРИЛТ

- Ногоон байгууламжийг тоог нэмэгдүүлэх, эрүүл орчин бүрдүүлэх
- Хүүхэд байгаль дэлхийгээ хамгаалах үйлд суралцах

ХОЁР. ТӨСЛИЙН ЗОРИЛГО






- Цэцэрлэгийн гадна орчинд 76%-ийн ногоон байгууламжийг бий болгох

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ҮР ДҮН


Хүүхэд бага бялчир наснаасаа байгаль дэлхийгээ танин мэдэх, хайрлан хамгаалах үйл суралцах, эрүүл таатай орчинд хөгжин, нийгэмшүүхүйн үйлд суралцах юмаа. Мөн хүүхэд өөртөө үйлчлэх үйлд суралцах, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндлэх хайрлан хамгаалах зэрэг олон сайн зүйлийг олж авах юмаа.

ТАВ. ТӨСӨВ

№	Ногоон байгууламжийн хэрэгслүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/	Зураг
1	Зүлэгний үр, 660мкв талбайд /төв цэцэрлэг - 445мкв салбар цэцэрлэг – 215мкв/	кг	26	45,000.0	1,170,000.0	
2	Хар шороо, элстэй холимог /5см өтгөн хөрсөнд/	м.куб	42	50,000.0	2,100,000.0	
4	Гацуур /гоёлын өтгөн 3-4 настай/	ш	7	450,000.0	3,150,000.0	
5	Хамгаалалтын тор /дөнгөж ургаж байгаа гацуурт хэрэглэдэг 1,2-1,5м өндөртэй зориулалтын хуванцар тор/	метр	14	8,000.0	112,000.0	
6	Цэцгийн мандал /гадна сааданд цэцэг тарих жижиг цэцгийн савыг банз ашиглан хийх/	ш	10	216,500.0	2,165,000.0	
	6.1. Банз /10см өргөнтэй 4м урттай, 1 ширхэг банзны үнэ 7,500.0 төгрөг орчим/	ш	15-18	135,000.0	135,000.0	
	6.2. Тосон будаг /Модонд зориулсан будаг/	л	3	45,000.0	45,000.0	
	6.3. Модны лак /гадна орчинд зориулагдсан лак/	лааз	1	25,000.0	25,000.0	
	6.4. Хадаас, шрүп /5.5x150mm/	хайрцаг	1	11,500.0	11,500.0	
7	Гадна мандалын олон наст цэцгийн үр /1уутанд 5-10ш/	ш	80	7,000.0	560,000.0	

8	Хүлэмж /нар бууруулагч хар тор, хэмжээ 3*4/	ш	2	950,000.0	1,900,000.0	
9	Усалгааны систем • шланг • бороожуулагч толгой • насос • 1тн-ийн сав	багц	2	512,000.0	1,024,000.0	-
	9.1. 1тн-ийн хуванцар сав	ш	1	250,000.0	250,000.0	
	9.2. Шланг /Зөөврийн шар шланг 20мм зузаан/	м	50	100,000.0	100,000.0	
	9.3. Бороожуулагч толгой /SKU:5175427525/	ш	1	12,000.0	12,000.0	
	9.4. Насос /12V насос/	ш	1	150,000.0	150,000.0	
Нийт		-	-	-	12,181,000.0	-

ЗУРГАА. ХҮЛЭМЖНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Нэр төрөл, үзүүлэлт	Тодорхойлолтын шаардлага	
1	Стандарт	Бараа материал нь олон улсын хэмжээнд болон монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна. ISO9001:2008, ISO14001:2015. MNS6636:2016 стандартын шаардлага тус тус хангасан байна.	
2	Байршил	Дархан сум 15-р баг 11-р цэцэрлэг	
3	Тоног төхөөрөмж	Нуман хэлбэрийн хүлэмж нийлүүлэх	
4	Хүлэмж нийлүүлэх нийт үнэ	Нийт: 2ш*950,000.0=1,900,000.0	
5	Нийлүүлэх хүлэмжний тоо	Нийт 2 ширхэг нийлүүлэх	
6	Нийлүүлэх хүлэмжний хэмжээ	Хүлэмж нь 12м.кв буюу 3 метр өргөн, 4 метр урттай байна.	
	Зураг		
7	Техникийн ерөнхий үзүүлэлт	Хар тор	Хүлэмжийг хэт халахаас хамгаалж ургамал муужрахаас сэргийлнэ. Нарны гэрлийг 55% бууруулна. Сайжруулсан хар сүлжмэл тор.
		Хүлэмжийн агааржуулагч	Хүлэмж нь 2 талдаа механикаар нээгдэж хаагддаг агааржуулагч салхивчтай байх
		Хүлэмжний нийлэг хальс	<ul style="list-style-type: none"> - 40-өөс +50 хэмд физик чанараа алддаггүй, - 0,13мм -ээс дээш зузаантай - ашиглалтын хугацаа 3 жилээс доошгүй - хүлэмжийн зориулалттай - 3 давхараат бүтэцтэй - усан дусал үүсгэддэггүй - хэт ягаан туяаны хамгаалалттай - урт хугацаанд ашиглах зориулалтыг илтгэсэн РО гэсэн бичиг тэмдэглэлтэй байх
		Нийлэг хальс бэхлэлт	Хийлэг хальсыг тогтоогч зам төмөр нь 1мм багагүй зузаан байх, нийлэг хальсыг 1м-ээс багагүй зайд эвдрэхгүй зориулалтын уяагаар даруулж бэхлэх, уяаг газрын гүнд 50см багагүй суулгасан гадсанд тогтоож бэхлэх шаардлагыг хангасан байх
		Хүлэмжийн хаалга	Хүлэмжүүд 2 хаалгатай байх бөгөөд хоёр талруугаа шулуун зам дээр роликоор гүйж нээгдэж хаагддаг байх
		Усалгааны систем	SKU:51754267492 хоолой /шланк/, бороожуулагч толгой SKU:5175427525, 12V насос, 1тн-ийн усны сав

ХАВСРАЛТ /Одоогийн байдлаар/

/төв цэцэрлэг/



/салбар цэцэрлэг/

